



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар №328

Номбулаг:

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 81, 2019 оны "Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай" 223, аймгийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын 2019 оны "Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай" 74, 2023 оны "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Хөгжлийн банктай эргэн төлөгдөх гэрээний нөхцөлтэйгээр Солонго хорооплын нутаг дэвсгэрт 2 блок 120 айлын орон сууцны барилгын "Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах" 2020 оны 2/68 дугаар гэрээний зээлийн хүүгийн төлбөрт 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг шилжүүлсүгэй.

2. Зээлийн хүүгийн төлбөрт шаардагдах хөрөнгийг Засаг даргын ерөнхий дансны батлагдсан эх үүсвэрээс гаргаж, "Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


3. Тухайн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнахыг "Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Д.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР





ପ୍ରକାଶିତ ଦିନାଂକ ୧୯୮୫ ଜାନୁଆରୀ

ମେଲାର୍ଯ୍ୟ ପିଲାଗାନ୍ତି ପତ୍ରାଳି

18 Nov      8M      22

विद्युती

દુર્ગા પત્રિ



ପାଇଁ କାହାରୁ ଦିଲ୍ଲିରେ ଏହାରୁ ନାହିଁ